



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Даланзадгад хот

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn

Аудитор: С.Одончимэг

Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.02.24 № 91

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-Овоо сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал-Овоо сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ соёлын төвийн барилга баригдаж байна.

Аудитын гол асуудал

Интернет холболтын үйлчилгээ авахаар Монголын цахилгаан холбоо ТӨХК-д 2,000,000 төгрөг урьдчилж төлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016020162

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,951,240.00</u>	<u>39,755,480.63</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	22,813,436.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	22,813,436.05
31211	Төрийн сангийн харилцах	-	22,813,436.05
33	АВЛАГА	-	39,424.58
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	39,424.58
34	УРЬДЧИЛГАА	-	2,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,951,240.00	14,902,620.00
354	Хангамжийн материал	19,951,240.00	14,902,620.00
35420	Аж ахуйн материал	19,951,240.00	14,902,620.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>725,081,111.30</u>	<u>685,677,067.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	725,081,111.30	685,677,067.58
392	Биет хөрөнгө	721,073,111.30	667,913,067.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	649,133,182.04	649,133,182.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,602,957.84)	(58,059,299.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,500,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(10,925,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,752,739.00	107,902,739.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,702,541.60)	(74,782,657.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,786,275.80	18,503,519.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,218,708.10)	(6,214,538.22)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	21,077,700.00	21,077,700.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,250,000.00	2,250,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(630,000.00)	(1,050,000.00)
39217	Ном	8,652,422.00	9,152,422.00
393	Биет бус хөрөнгө	4,008,000.00	17,764,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,008,000.00	17,764,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>745,032,351.30</u>	<u>725,432,548.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,725,552.99</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,725,552.99	-
413	Өглөг	6,725,552.99	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	259,312.99	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,466,240.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>738,306,798.31</u>	<u>711,676,548.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	738,306,798.31	711,676,548.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	475,871,050.91	475,871,050.91
51101	Өмч: - төрийн	475,871,050.91	475,871,050.91
512	Хуримтлагдсан үр дүн	127,267,427.51	100,637,177.41
51210	Өмнөх үеийн үр дүн	127,267,427.51	127,526,740.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	(26,889,563.09)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,168,319.89	135,168,319.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>745,032,351.30</u>	<u>711,676,548.21</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	157,403,120.00	154,968,736.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	157,403,120.00	154,968,736.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	86,591,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	86,591,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,860,620.00	1,937,336.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,860,620.00	1,937,336.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,542,500.00	65,639,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,542,500.00	65,639,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	800,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	800,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	224,777,647.53	176,133,299.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,777,647.53	176,133,299.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	171,920,744.20	163,070,472.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,649,719.00	49,892,486.42
210101	Үндсэн цалин	53,649,719.00	49,892,486.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,454,759.50	6,489,477.58
210201	Тэтгэврийн даатгал	5,199,862.78	4,492,448.76
210202	Тэтгэмжийн даатгал	536,496.82	499,302.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	507,194.91	399,255.89
210204	Ажилгүйдлийн даатгал	107,298.72	99,864.23
210205	Эрүүл мэндийн даатгал	1,103,906.27	998,606.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,247,448.00	46,885,051.00
210301	Гэрэл, цахилгаан	863,768.00	1,621,371.00
210302	Түлш, халаалт	45,263,680.00	45,263,680.00
210303	Цэвэр, бохир ус	120,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,785,740.00	14,477,690.00
210401	Бичиг хэрэг	1,530,300.00	71,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,999,240.00	1,994,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	123,900.00
210404	Ном, хэвлэл	48,300.00	-
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	132,900.00	6,288,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	6,000,000.00
2105	Нормативт зардал	60,000.00	60,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000.00	60,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,008,100.00	-
210604	Урсгал засвар	18,008,100.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	208,000.00
210702	Дотоод албан томилолт	-	208,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,491.00	3,122,724.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,491.00	3,122,724.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,478,486.70	41,935,043.72
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	42,478,486.70	41,935,043.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,856,903.33	13,062,826.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,616,220.00	2,417,003.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,455,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,160,620.00	2,417,003.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	33,240,683.33	10,645,823.37
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,240,683.33	10,645,823.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(67,374,527.53)	(21,164,563.09)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,204,166.67	20,125,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,204,166.67	20,125,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,204,166.67)	(20,125,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(68,578,694.20)	(41,289,563.09)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	157,436,420.83	154,968,736.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,300.83	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,300.83	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,300.83	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	157,403,120.00	154,968,736.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	86,591,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	86,591,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,860,620.00	1,937,336.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,860,620.00	1,937,336.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,542,500.00	65,639,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,542,500.00	65,639,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	800,000.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	157,436,420.83	131,655,299.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	157,436,420.83	131,655,299.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,579,517.50	118,592,473.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,649,719.00	49,892,486.42
210101	Үндсэн цалин	41,426,298.00	44,721,209.78
210102	Нэмэгдэл	12,223,421.00	4,069,433.64
210104	Урамшуулал	-	1,101,843.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,454,759.50	6,528,902.16
210201	Тэтгэврийн даатгал	5,199,862.78	4,531,872.84
210202	Тэтгэмжийн даатгал	536,496.82	499,303.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	507,194.91	399,255.89
210204	Ажилгүйдлийн даатгал	107,298.72	99,864.23
210205	Эрүүл мэндийн даатгал	1,103,906.27	998,606.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,781,208.00	53,351,291.00
210301	Гэрэл, цахилгаан	863,768.00	1,621,371.00
210302	Түлш, халаалт	38,797,440.00	51,729,920.00
210303	Цэвэр, бохир ус	120,000.00	-

2104	Хангамж, бараа материалын зардал	2,356,340.00	2,339,690.00
210401	Бичиг хэрэг	83,800.00	71,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,999,240.00	1,994,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	123,900.00
210404	Ном, хэвлэл	48,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00
2105	Нормативт зардал	60,000.00	60,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000.00	60,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	594,000.00	1,089,380.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,089,380.00
210604	Урсгал засвар	594,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	-	208,000.00
210702	Дотоод албан томилолт	-	208,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,491.00	3,122,724.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	236,491.00	3,122,724.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	447,000.00	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	447,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,856,903.33	13,062,826.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,616,220.00	2,417,003.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,455,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,160,620.00	2,417,003.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	33,240,683.33	10,360,490.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	33,240,683.33	10,360,490.37
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	285,333.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	285,333.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	23,313,436.05
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	500,000.00
223001	Бусад хөрөнгө	-	500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(500,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	22,813,436.05
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,813,436.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	475,871,050.91	135,168,319.89	127,267,427.51	738,306,798.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	259,312.99	259,312.99
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-		-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	13,756,000.00	-	-	13,756,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(26,889,563.09)	(26,889,563.09)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	489,627,050.91	135,168,319.89	100,637,177.41	725,432,548.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	152,531,400.00	119,357,473.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152,531,400.00	119,357,473.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	151,763,400.00	118,592,473.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	67,171,000.00	49,892,486.42
210101	Үндсэн цалин	47,953,000.00	44,721,209.78
210102	Нэмэгдэл	15,084,200.00	4,069,433.64
210104	Урамшуулал	4,133,800.00	1,101,843.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,396,200.00	6,528,902.16
210201	Тэтгэврийн даатгал	5,709,500.00	4,531,872.84
210202	Тэтгэмжийн даатгал	671,800.00	499,303.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	537,300.00	399,255.89
210204	Ажилгүйдлийн даатгал	134,400.00	99,864.23
210205	Эрүүл мэндийн даатгал	1,343,200.00	998,606.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,992,500.00	53,351,291.00
210301	Гэрэл, цахилгаан	4,054,100.00	1,621,371.00
210302	Түлш, халаалт	58,818,400.00	51,729,920.00
210303	Цэвэр, бохир ус	120,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	2,358,400.00	2,339,690.00
210401	Бичиг хэрэг	84,600.00	71,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	1,994,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	123,800.00	123,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,000.00	150,000.00
2105	Нормативт зардал	60,000.00	60,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000.00	60,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,089,380.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	1,089,380.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	208,000.00

210702	Дотоод албан томилолт	250,000.00	208,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,435,300.00	3,122,724.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,435,300.00	3,122,724.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	765,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	765,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	765,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152,231,400.00	141,870,909.63
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,591,700.00	86,591,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	86,591,700.00	86,591,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	65,639,700.00	55,279,209.63
132001	Орон нутгийн төсвөөс	65,639,700.00	55,279,209.63
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		22,813,436.05

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,652,003.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,652,003.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,652,003.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,652,003.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,652,003.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,652,003.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,652,003.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,652,003.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 24.3 сая төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Интернет холболтын үйлчилгээнд Монголын цахилгаан холбоо ТӨХК-д урьдчилж шилжүүлсэн 2.0 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардалд тайлагнаагүй
- Орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн 10.4 сая төгрөг, нэмэлт данснаас төвлөрүүлсэн 0.3 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг 213303 улсын төсвөөс олгосон төвлөрүүлэх шилжүүлэг дансанд тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 0.5 сая төгрөгийн номыг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Бараа материалын данснаас тавилга эд хогшил дансанд шилжүүлэн авсан 6.0 сая төгрөгийн өртөг бүхий сүүдрэвчийг 120017 үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнасан
- Орлого үр дүнгийн тайланд нэмэгдэл цалин, урамшуулалт цалингаар тус тус харуулаагүй 210101 тоот дансанд бөөн дүнгээр тайлагнасан байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага, өгөгдөөгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Байгууллагын даргын тушаал шийдвэр нь эрх зүйн чадамжгүй, баримт бичгийг зохих стандартын дагуу бэлтгээгүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 "Байгууллагын удирдлага албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, албан хэрэг хөтлөлтөд цахим тогтолцоог нэвтрүүлэх, холбогдох ажилтныг мэргэшүүлэх болон баримт бичгийг заавар, журам, стандартын дагуу зохион бүрдүүлж хөтлөх, тэдгээрийг хадгалах, ашиглах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавина", 37 дугаар зүйлийн 37.2 "Баримт бичгийг зохиож бүрдүүлэхдээ стандартын шаардлагыг мөрдөнө"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Баримт бичгийн албан ёсны хүчин төгөлдөр байдлыг хангах, архив, албан хэргийн хөтлөлтийн сургалтад эрх бүхий этгээдийг хамруулах, мэргэшүүлэхэд анхаарч ажиллах

Илрүүлэлт 2: Улирлын ажлын үр дүнг үнэлж жилийн эцэст 1 удаа, байгууллагын дотоод журмыг үндэслэн хариуцсан ажилдаа идэвх зүтгэл гаргасан албан хаагчдад 11, 12 дугаар сард нэмэгдэл урамшуулал тус тус олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсийг ажлын гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгож ажиллах

2. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тус Соёлын төвийн төлбөрт үйлчилгээний үнэ, тарифыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаагүй, үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого төвлөрүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн орон нутгийн өмчийн үр ашгийг дээшлүүлэх, зохих ёсны өөрийн орлого бүрдүүлж ажиллах

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол батлагдаж суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг хязгаарласантай холбоотойгоор тус байгууллага үндсэн үйл ажиллагаанаас бусад тохиолдолд албан хаагчдад шатахуун зарцуулж ажилласан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх"-д заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн чиг үүргийг гүйцэтгэх ажлаас бусад тохиолдолд төсвийн хөрөнгийг хэмнэлтэй үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитыг газарт 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Интернет холболтын үйлчилгээнд Монголын цахилгаан холбоо ТӨХК-д урьдчилж шилжүүлсэн 2,000.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардалд тайлагнаагүй	1	2,000.0	1	2,000.0			1	2,000.0				
Орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн 10,360.5 мянган төгрөг, нэмэлт данснаас төвлөрүүлсэн 285.3 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг 213303 улсын төсвөөс олгосон төвлөрүүлэх шилжүүлэг дансанд тайлагнасан байна	1	10,645.8			1	10,645.8	1	10,645.8				
Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 500.0 мянган төгрөгийн номыг хөрөнгө оруулалтын зардлаар бүртгэж тайлагнаагүй байна	1	500.0	1	500.0			1	500.0				
Бараа материалын данснаас тавилга эд хогшил дансанд шилжүүлэн авсан 6,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий сүүдрэвчийг 120017 үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор тайлагнасан байна.	1	6,000.0			1	6,000.0	1	6,000.0				
Орлого үр дүнгийн тайланд нэмэгдэл цалин, урамшуулалт цалингаар тус тус харуулаагүй 210101 тоот дансанд бөөн дүнгээр тайлагнасан байна.	1	5,171.3			1	5,171.3	1	5,171.3				
Дүн	5	24,317.1	2	2,500.0	3	21,817.1	5	24,317.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын даргын тушаал шийдвэр нь эрх зүйн чадамжгүй, баримт бичгийг зохих стандартын дагуу бэлтгээгүй байна	1	0					1	0				
Улирлын ажлын үр дүнг үнэлж жилийн эцэст 1 удаа, байгууллагын дотоод журмыг үндэслэн хариуцсан ажилдаа идэвх зүтгэл гаргасан албан хаагчдад 11, 12 дугаар сард нэмэгдэл урамшуулал тус тус олгосон байна.	1	1,632.4					1	1,632.4				
Тус Соёлын төвийн төлбөрт үйлчилгээний үнэ, тарифыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулаагүй, үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого төвлөрүүлж ажиллаагүй байна.	1	0					1	0				
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай ЗГ-ын тогтоол батлагдаж суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтныг хязгаарласантай холбоотойгоор тус байгууллага үндсэн үйл ажиллагаанаас бусад тохиолдолд албан хаагчдад шатахуун зарцуулж ажилласан байна.	1	1,441.5					1	1,441.5				
Дүн	4	3,073.9					4	3,073.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд тавигдах 6 мэдээллийг хоцруулан байршуулсан, тухайн жилийн төсөв, хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, аудитын дүгнэлт, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 9,461,209 төгрөгийн 1 ажил гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 51,729,920 төгрөгийн 8 ажил, гүйлгээ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тус тус оруулаагүй байна	1	61,191.1			1	61,191.1		
Дүн	1	61,191.1			1	61,191.1		